

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2016-2017, 2017-2018 ОНЫ  
ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ  
ХИЙСЭН ДҮНГИЙН МАТЕРИАЛ


Шалгалтанд хамрагдсан хугацаа: 2016,2017 он

Шалгалт эхэлсэн: 2018:04:02  
Шалгалт дууссан: 2018:04:13


Шалгасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын  
Салбарын санхүүгийн хяналт шалгалт  
хариуцсан мэргэжилтэн /улсын ахлах байцаагч/:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын  
Салбарын санхүүгийн хяналт шалгалт  
хариуцсан мэргэжилтэн /улсын байцаагч/:



Б.Чулуунбат



Г.Туул

Хуудасны тоо

УЛААНБААТАР ХОТ 2018 ОН

**ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016-2017, 2017-2018 оны төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн тухай

**Нэг. Хяналт шалгалтын зорилго.**

Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016-2017, 2017-2018 оны төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль, "Төсвийн тухай" хууль, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журам, норм, нормативын хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд шалгалтын зорилго чиглэгдлээ.

**Хоёр. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа.**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2016-2017, 2017-2018 оны төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын салбарын санхүүгийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн /улсын ахлах байцаагч/ Б.Чулуунбат, салбарын санхүүгийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн /улсын байцаагч/ Г.Туул нар 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс ажлын 07 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

**Гурав. Шалгалтанд хамрагдах асуудлууд**

Шалгалтаар "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт,

- Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаал 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 491/А472 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам",

-Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 97/56 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам"

- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хүмүүстэй байгуулсан гэрээ хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, эд хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгөний тооллого, тооцоо бодолт, байгууллага хүмүүстэй хийх тооцоо, хөрөнгө оруулалт, худалдан авалт, хандив тусламжаар авсан хөрөнгө, өөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг касс харилцахын үндсэн баримтаар нь тулган шалгаж санхүүгийн холбогдох хууль тогтоомж заавар журмын заалтыг үндэслэн шалгалаа.

**Дөрөв. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал.**

Шалгалтын үеэр иргэн, төвийн ажилтнаас санал гомдол ирээгүй болно.

Тухайн байгууллагын харъяалагдах дээд шатны болон санхүү, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шийдвэрлэх асуудал гараагүй болно.

Сургалтын болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар өмнөх он, төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа хийж ажилласан болно.

### 5.1 Санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төсвийн санхүүжилт, зардлын гүйцэтгэлийн талаар:

#### 5.1.1 Санхүүжилтийн эх үүсвэрийн талаар.

/мянган төгрөгөөр/

| № | Орлогын нэр              | 2016 он            |                    |                 | 2017 он            |                    |                  |
|---|--------------------------|--------------------|--------------------|-----------------|--------------------|--------------------|------------------|
|   |                          | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Хэтрэлт хэмнэлт | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Хэтрэлт хэмнэлт  |
| 1 | Улсын төсвийн санхүүжилт | 2.963.136,4        | 2.953.236,4        | 9.900,0         | 3.655.553,9        | 3.655.553,9        | -                |
| 2 | Үндсэн үйл ажиллагааны   | 346.000,0          | 353.657,7          | -7.657,7        | 340.000,0          | 353.943,3          | -13.943,3        |
| 3 | Туслах үйл ажиллагааны   | 100.000,0          | 111.767,0          | -11.767,0       | 100.000,0          | 101.269,5          | -1.269,5         |
| 4 | ЭШСХ,Нэмэлт төсөв данс   | 136.276,5          | 136.276,5          | -               | 248.984,1          | 243.988,1          | 4.996,0          |
| 5 | <b>Нийт</b>              | <b>3.545.412,9</b> | <b>3.554.937,6</b> | <b>9.554,7</b>  | <b>4.344.538,0</b> | <b>4.354.754,8</b> | <b>-10.216,8</b> |

- Үндсэн үйл ажиллагааны орлого давсан шалтгаан эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд орж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо нэмэгдсэнтэй, туслах үйл ажиллагааны орлого давсан шалтгаан эмч нарын байрны орыг эмч нар амралттай байх хугацаанд сул байлгалгүй бүрэн ашигласан болно.

#### 5.1.2 Төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн талаар.

/мянган төгрөгөөр/

| Зардлын нэр                                     | 2016 он            |                    |                 | 2017 он            |                    |                  |
|---|--------------------|--------------------|-----------------|--------------------|--------------------|------------------|
|   | төсөв              | Гүйцэтгэл          | Хэтрэлт хэмнэлт | Төсөв              | Гүйцэтгэл          | Хэтрэлт Хэмнэлт  |
| Цалин хөлс нэмэгдэл зардал                      | 768.372,1          | 750.261,3          | 18.110,7        | 787.052,7          | 786.846,0          | 206,7            |
| НДШ-ийн зардал                                  | 80.230,8           | 80.230,8           | -               | 83.275,8           | 83.275,8           | -                |
| Гэрэл цахилгааны зардал                         | 40.000,0           | 36.295,2           | 3.704,8         | 27.720,0           | 37.018,5           | -9.298,5         |
| Түлш халаалтын зардал                           | 25.577,8           | 25.522,3           | 55,4            | 30.895,8           | 24.050,7           | 6.845,0          |
| Цэвэр, бохир ус                                 | 19.287,5           | 15.429,2           | 3.858,3         | 19.800,0           | 15.937,1           | 3.862,8          |
| Бичиг хэрэг                                     | 15.546,4           | 15.420,7           | 125,7           | 15.804,9           | 24.483,9           | -8.679,0         |
| Тээвэр, шатахуун                                | 13.620,0           | 12.971,6           | 648,4           | 15.840,0           | 10.198,2           | 5.641,8          |
| Шуудан,холбоо                                   | 7.985,4            | 7.053,9            | 931,5           | 4.269,2            | 4.507,9            | -238,7           |
| Хог хаягдал устгах цэвэрлэх                     | 3.641,2            | 3.632,3            | 8,9             | 12.742,5           | 6.131,4            | 6.611,0          |
| Бага үнэтэй түргэн элэгдэх зардал               | 5.022,0            | 5.022,0            | -               | 13.742,2           | 16.270,5           | -2.528,3         |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл                     | -                  | -                  | -               | 485,1              | 354,0              | 131,0            |
| Багаж хэрэгсэл                                  | 25.000,0           | 24.549,8           | 450,2           | 29.750,0           | 24.408,9           | 5.341,1          |
| Урсгал засвар                                   | 24.552,7           | 21.600,3           | 2.952,4         | 23.577,8           | 28.918,3           | -5.340,5         |
| Дотоод томилот                                  | 9.119,1            | 9.098,1            | 21,0            | 28.021,2           | 20.874,6           | 7.146,5          |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж | 238.748,0          | 222.138,1          | 16.609,9        | 284.453,0          | 257.693,1          | 26.759,9         |
| Тээврийн хэрэгслийн даатгал                     | 770,0              | 508,4              | 261,6           | 2.852,0            | 903,3              | 1.948,9          |
| Мэдээллийн технологийн үйлчилгээ                | 12.419,2           | 10.124,5           | 2.294,7         | 12.295,0           | 12.271,3           | 23,7             |
| Тээврийн хэрэгслийн татвар                      | 880,0              | 423,5              | 456,5           | 871,2              | 128,2              | 743,0            |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо                   | 187,0              | 67,0               | 120,0           | 185,1              | -                  | 185,1            |
| Газрын төлбөр                                   | 750,0              | 423,5              | 326,4           | 742,5              | 418,0              | 324,5            |
| Улсын мэдээллийн маягт                          | 33.000,0           | 24.287,9           | 8.712,1         | 32.670,0           | 32.669,7           | 0,2              |
| Сургалт, тэтгэлэгийн зардал                     | 2.025.300,0        | 1.913.697,4        | 111.602,6       | 2.644.807,7        | 2.535.132,1        | 109.675,6        |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал                 | -                  | -                  | -               | 23.700,0           | 23.310,0           | 390,0            |
| Тэтгэвэрийн тэтгэмж                             | 59.127,0           | 59.127,0           | -               | -                  | -                  | -                |
| Төвлөрүүлэг шилжүүлэг                           | -                  | 180.775,8          | -180.775,8      | -                  | 165.566,7          | -                |
| <b>Нийт дүн</b>                                 | <b>3.409.136,2</b> | <b>3.418.660,6</b> | <b>9.524,7</b>  | <b>4.095.553,7</b> | <b>4.111.361,2</b> | <b>-15.814,9</b> |

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2016 онд 2.025.300,0 төгрөг батлагдсан ба 1.913.697,0 төгрөгийг сургалтын үйл ажиллагаанд зарцуулж, 111.602,6 төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэлтэй гарсан байна.

2016 онд нийт 180.775,8 төгрөг хэмнэж, 2017 онд нийт 165.566,7 төгрөг хэмнэж татан төвлөрүүлсэн байна.

**Сургалтын зардал хэмнэлтийн шалтгаан:** Эрүүл мэндийн сайдын сургалтын зардал, хяналтын тоо батлах тухай тушаалаар батлагдсан тооноос төрөлжсөн мэргэжилтэн, тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд орон нутгаас ирж суралцаагүй нь нөлөөлсөн байна. Мөн 2016 онд сургалт эхлэх хугацаа хойшлогдож, 11 дүгээр сард эхэлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн захиалгын дагуу ирж суралцах эмнэлгийн мэргэжилтэнүүд ирж суралцахгүй байгаа шалтгаан нь тухайн мэргэжлийн чиглэлээр орлон ажиллах мэргэжилтэн байхгүй, хөдөө орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаатай холбоотой байна.

**Төрийн зардлаар суралцуулах төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтын зардлын тооцоо /2016 он/**

/мянган төгрөгөөр/

| №                           | Сургалтын төрөл   | ЭМС-ын тушаал буюу хяналтын тоо |                          | Гүйцэтгэл        |                    | Зөрүү            |                  |
|-----------------------------|---|---------------------------------|--------------------------|------------------|--------------------|------------------|------------------|
|                             |   | Суралцагчдын тоо                | Төсөв /мянган төгрөгөөр/ | Суралцагчдын тоо | Зардал             | Суралцагчдын тоо | Зардал           |
| 1                           | Үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал   | 1085                            | 413.440.0                | 611              | 289.757.6          | 474              | 123.682.4        |
| 2                           | Үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын тэтгэлэг | 446                             | 1.077.300.0              | 398              | 999.576.3          | 48               | 77.723.6         |
| <b>Багц цагийн сургалт:</b> |   |                                 |                          |                  |                    |                  |                  |
| I                           | Ажлын байрны сургалт  | 1365                            | 277.760.0                | 105.000          | 248.502.7          | 103.635          | 29.257.3         |
| II                          | Зайн сургалт  | 2000                            | 6.800.0                  | 1250             | 4.501.5            | 750              | 2.298.5          |
| <b>Бусад сургалт:</b>       |   |                                 |                          |                  |                    |                  |                  |
| 1                           | Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалт                                    | 80                              | 338.000.0                | 101              | 347.226.3          | -21              | -9.226.2         |
| 8                           | Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ                         | -                               | 10.000.0                 | -                | 3.200.0            | -                | 6.800.0          |
|                             | Сургалтын зардлын 5%  | -                               | 20.932.8                 | -                | 20.932.8           | -                | -                |
|                             | <b>Нийт зардал</b>  |                                 | <b>2.123.300.0</b>       |                  | <b>1.913.697.3</b> |                  | <b>209.602.6</b> |

**Төрийн зардлаар суралцуулах төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтын зардлын тооцоо /2017 он/**

| №                           | Сургалтын төрөл   | Суралцагчдын тоо | Төсөв /мянган төгрөгөөр/ | Гүйцэтгэл        |                    | Үлдэгдэл         |                  |
|-----------------------------|---|------------------|--------------------------|------------------|--------------------|------------------|------------------|
|                             |   |                  |                          | Суралцагчдын тоо | Зардал             | Суралцагчдын тоо | Зардал           |
| 1                           | Үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал   | 1045             | 523.104.0                | 657              | 439.094,2          | 388              | 84.009,8         |
| 2                           | Үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын тэтгэлэг | 490              | 1.250.100,0              | 476              | 1.119,879,2        | 14               | 130,220,8        |
| <b>Багц цагийн сургалт:</b> |   |                  |                          |                  |                    |                  |                  |
| I                           | Ажлын байрны сургалт  | 2317             | 340,417,5                | 28000            | 330,882,6          | -25683           | 9,534,8          |
| II                          | Зайн сургалт  | 250              | 9,500,0                  | 105              | -                  | 145              | 9,500,0          |
| <b>Бусад сургалт:</b>       |   |                  |                          |                  |                    |                  |                  |
| 1                           | Эрүүл мэндийн ажилтний гадаад сургалт                                   | 126              | 515,981,9                | 126              | 593,210,9          | -                | (77,228,9)       |
| 8                           | Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн үнэлгээ                         | -                | 5,000,0                  | -                | 1,167,0            | -                | 3,833,0          |
|                             | Сургалтын зардлын 5%  | -                | -                        | -                | 50,898,0           | -                | -                |
|                             | <b>Нийт зардал</b>  |                  | <b>2,644,103,5</b>       |                  | <b>2,535,132,0</b> |                  | <b>108,971,4</b> |

**5.1.3 Нэмэлт санхүүжилтийн талаар:**

| Зардлын нэр  | 2016 он  |          |         | 2017 он   |           |         |
|--|----------|----------|---------|-----------|-----------|---------|
|  | Орлого   | зарлага  | зөрүү   | Орлого    | зарлага   | зөрүү   |
| ДЭМБ ЭМБ-ын статистик мэдээллийн үйл ажиллагаанд ХШҮ хийх улирлын мэдээлэл боловсруулах                | 6.074,2  | 6.074,2  | -       | 4.585,00  | 4.585,00  | -       |
| ДЭМБ "ЭМ-ийн үндэсний тогтолцоо" ажлын хөлс  | 11.135,0 | 11.135,0 | -       | 7.288,4   | 7.288,4   | -       |
| Зүрх судасны төв МОН/005 сургалтын санхүүжилт  | 3.140,0  | -        | 3.140,0 | 3.140,0   | 3.140,0   | -       |
| ДЭМБ /H-info программ шинэчлэл/  | 61.220,0 | 59.507,2 | 1.712,8 | 112.949,8 | 112.807,3 | 142,5   |
| Люксембург сургалт зардал  | 54.707,3 | 53.503,8 | 1.203,4 | 1.203,4   | 1.203,4   | -       |
| ДЭМБ Эрүүл мэндийн үзүүлэлт ном хэвлэх бусад   | -        | -        | -       | 21.195,0  | 21.184,0  | 10,9    |
| ДЭМБ Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага | -        | -        | -       | 22.101,5  | 22.101,5  | -       |
| НҮБ-ХАСан Улс орныг дэмжих 6-р хөтөл-бөрийн хүрээнд смарт утасны аппликейшин боловсруулах,             | -        | -        | -       | 71.525,0  | 66.529,0  | 4.995,9 |

|  |           |           |         |           |           |         |
|--|-----------|-----------|---------|-----------|-----------|---------|
| тоног төхөөрөмжийн судалгаа хийх төсөл |           |           |         |           |           |         |
| Нийт дүн                               | 136.276,5 | 132.720,2 | 6.056,2 | 243.988,1 | 238.838,5 | 5.149,6 |

• ДЭМБ-аас Н-info программыг шинэчлэх багийн ажлын зардалд 61.220,0 мянган төгрөг, “МУ-ын эрүүл мэндийн нийт зардлын үндэсний тооцооны дотоодын зөвлөх, судалгааны туслах ажилтан”-ны зардал болох 11.135,0 мянган төгрөг нийт 72.355,0 мянган төгрөг орсон ба Н-info программыг шинэчлэх багийн ажлын зардлаас 1.712,8 мянган төгрөг нь үлдсэн байна.


**2017 онд ДЭМБ-аас:** “Үндэсний эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгоход байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн 111.237,0 мянган төгрөг

**НҮБ-ын ХАС-аас:** “Улс орныг дэмжих 6 дугаар хөтөлбөрийн хүрээнд смарт утасны аппликейшин боловсруулах, тоног төхөөрөмжийн судалгаа хийх төслийн санхүүжилт 71.525,0 мянган төгрөг

#### 5.1.4 Төгсөлтийн дараахь гадаад сургалтын талаар 2016-2017 он:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь 2013 оноос эрүүл мэндийн ажилтанг гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж эхэлсэн.

2013-2016 онд гадаад улсад мэргэжил дээшлүүлсэн эмч мэргэжилтний тоо



**Гадаад сургалтан 2016 онд 101 эмнэлгийн ажилтан хамрагдснаар тайлагнасан боловч 68 мэргэжилтэн нь сургалтанд хамрагдаж 33 эмнэлгийн ажилтан 5-14 хоногоор гадаад улсад аялал маягаар явсан байна.**

2017 онд 126 эрүүл мэндийн ажилтныг гадаад сургалтад хамруулсан байна. Үүнд: Тэргүүлэх чиглэлийн хүрээнд төрөлжсөн мэргэжлийн 12 чиглэлээр 46 БНСУ, БНЭУ, АНУ зэрэг орнуудад эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтан, нийгмийн эрүүл мэндийн удирдах болон менежерийн түвшний сургалтанд 80 эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтнийг Бүгд Найрамдах Сингапур Улсад нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо, бодлого зорилт, стратеги, үйл ажиллагааны чиглэлтэй танилцах сургалтанд, халдварт болон халдварт бус өвчний шалтгаан, тандалт судалгаа, статистик мэдээллийн урсгалын зохицуулалт, дүн шинжилгээ, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад нөлөөлөх сургалт, БНХАУ-ын Өвчний хяналтын төвд зохион байгуулсан сургалтанд 2 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан байна.

#### 5.1.5 Эмнэлгийн мэргэжил дээшлүүлэх сургалт 2016-2017 он:

**Төлөвлөлтийн талаар:** Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцуулах суралцагчдын захиалга ирүүлэх тухай төвийн албан бичгийг Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлж захиалгыг хүлээн авч нэгтгэн хяналтын тооны төслийг боловсруулахдаа:

1. Сүүлийн 5 жилд төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлээр суралцсан хүний тоо

2. Бүтэц үйл ажиллагааны стандартад заасан хүний нөөцийн доод хязгаар

3. Одоо ажиллаж байгаа хүний нөөцийн тоо

4. 2018-2020 онд тэтгэвэрт гарах хүний нөөцийн тоо

5. 2016, 2017 онд төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцагчдын тоо

6. Сургалт эрхлэгч байгууллагын хүчин чадал, багтаамж

7. Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцуулах хяналтын тоо

8. Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий их дээд сургуулийг 2016, 2017 оны хичээлийн жилд төгсөгчдийн тоо зэрэг шалгуурыг харгалзан төлөвлөдөг байна.

**Цаашид анхаарах асуудал:**

1. Эрүүл мэндийн байгууллагуудын төгсөлтийн дараах сургалтын төлөвлөлт бодитой биш. Элсэлтийн шалгалтын үед нэмэлтээр эмнэлгийн мэргэжилтэн суралцуулах хүсэлт ирүүлдэг.

2. Батлагдсан хяналтын тоо, мэргэшлийн чиглэлийн дагуу эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад бүрэн хамруулахгүй, мэргэшлийн чиглэл, суралцагчдын тоог элсэлтийн шалгалтын урд өдөр солих тохиолдол байдаг.

3. Төгсөлтийн дараах сургалтад элсэгчдийг элсэлтийн шалгалтад бэлдүүлэх, дэмжлэн үзүүлэх ажил хангалтгүй.

**2016-2017 онуудын төгсөлтийн дараах сургалтанд:**

| Сургалтын хэлбэр   | Элссэн      |             | Үүнээс     |            |             |           |                 |            |
|--------------------|-------------|-------------|------------|------------|-------------|-----------|-----------------|------------|
|                    | 2016 он     | 2017 он     | Төрийн сан |            | байгууллага |           | Хувийн зардлаар |            |
|                    |             |             | 2016 он    | 2017 он    | 2016 он     | 2017 он   | 2016 он         | 2017 он    |
| Үндсэн мэргэшлийн  | 385         | 480         | 200        | 257        | 13          | 7         | 178             | 216        |
| Төрөлжсөн эмч      | 203         | 145         | 90         | 82         | 17          | 24        | 96              | 49         |
| Төрөлжсөн сувилагч | 628         | 415         | 308        | 318        | 75          | 25        | 235             | 72         |
| <b>Нийт</b>        | <b>1215</b> | <b>1050</b> | <b>608</b> | <b>657</b> | <b>105</b>  | <b>56</b> | <b>509</b>      | <b>337</b> |

**2016-2017 оны төгсөлтийн дараах сургалтын мэдээлэл**

| Сургалтын хэлбэр                                     | Төлөвлөгдсөн |             |            |            | Суралцсан   |             |            |            | дутуу      |            |
|--|--------------|-------------|------------|------------|-------------|-------------|------------|------------|------------|------------|
|  | Нийт         |             | Төрийн сан |            | Нийт        |             | Төрийн сан |            | 2016 он    | 2017 он    |
|  | 2016 он      | 2017 он     | 2016 он    | 2017 он    | 2016 он     | 2017 он     | 2016 он    | 2017 он    |            |            |
| Үндсэн мэргэшил                                      | 518          | 517         | 200        | 289        | 510         | 480         | 199        | 257        | 1          | 32         |
| Төрөлжсөн мэргэшил (эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн) | 277          | 736         | 176        | 174        | 203         | 155         | 90         | 82         | 86         | 92         |
| Төрөлжсөн мэргэшил (сувилагч, тусгай мэргэжилтэн)    | 1028         | 858         | 400        | 391        | 628         | 415         | 322        | 318        | 78         | 73         |
| <b>Дүн</b>   | <b>1823</b>  | <b>2111</b> | <b>776</b> | <b>854</b> | <b>1341</b> | <b>1050</b> | <b>611</b> | <b>657</b> | <b>165</b> | <b>197</b> |

➤ **2017 онд төлөвлөгдсөн** Ерөнхий мэргэшил судлал сургалтад 32 суралцагч төрийн сангаар элсүүлэхээр төлөвлөсөн боловч сургалтын хөтөлбөр батлагдаагүй учир суралцагч элсүүлээгүй, зардлыг гадаад сургалтын зардал уруу шилжүүлсэн байна.

**2017-2018 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах үндсэн мэргэжлээр суралцуулах хяналтын тоо болон улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцагчдын тоонд дараах чиглэлээр нэмэлтээр:**

➤ Нүүр амны гажиг судлал чиглэлээр Увс аймгийн захиалгатай 1 элсэгч шалгалтад ороогүй байна.

➤ Анатомын эмгэг судлал чиглэлээр Архангай аймгийн захиалгатай 1 элсэгч шалгалтад тэнцээгүй, хувийн зардлаар суралцах 2 элсэгч шалгалтад тэнцээгүй учир элсүүлээгүй байна.

➤ Арьс судлал чиглэлээр хувийн зардлаар суралцахаар элсэлтийн шалгалтад хамрагдсан суралцагчдын тоо их байсан учир АӨСҮТ-өөс 6 элсэгч нэмж суралцуулах боломжтой тухай албан бичиг ирүүлсний дагуу нэмж 6 элсэгчийг хувийн зардлаар суралцуулахаар элсүүлсэн байна.

➤ Дотрын анагаах судлал, нүүр амны мэс засал чиглэлээр Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын хүсэлтээр улсын төсвийн санхүүжилтээр суралцах 1 элсэгчийг нэмж элсүүлсэн байна.

➤ Дүрс оношлогоо, Анатоми судлал чиглэлээр Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн захиалгаар 2 элсэгчийг улсын төсвийн санхүүжилтээр элсүүлсэн байна.

➤ Ерөнхий мэргэшил судлал чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд элсэлт аваагүй, 32 суралцагчийн сургалтын зардлыг гадаад сургалтын зардал уруу шилжүүлсэн байна.

➤ Нүд судлал чиглэлээр Ховд аймгийн захиалгаар 1 элсэгчийг улсын төсвийн санхүүжилтээр нэмэлтээр элсүүлсэн байна.

#### 5.1.6 Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтанд 2012-2017 онд улсын төсвийн хөрөнгөөр суралцаж төгсөгчдийн гэрээний хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийсэн талаар:


2012-2017 оны хичээлин жилүүдэд төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцаж төгсөгчдийн гэрээний биелэлтэнд үнэлгээ хийсэн байна.

Улсын төсвийн санхүүжилтээр суралцагчдын тоо

| № | Хүний тоо           | Үүнээс: |      |      |      |      |      |     |
|---|---------------------|---------|------|------|------|------|------|-----|
|   |                     | 2012    | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |     |
|   | Суралцсан хүний тоо | 677     | 69   | 74   | 94   | 151  | 129  | 134 |

Дүрслэл 1. Суралцагчдын тоо, он тус бүрээр графикаар харуулбал:

#### Улсын төсвийн санхүүжилтээр суралцагчдын тоо



**Гурвалсан гэрээгээр нийт 613 төгсөгч буюу 90.5 хувь нь захиалгат эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бол 64 төгсөгч буюу 9,5 хувь нь ажиллаагүй байна.**

**Зургаа. Шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар.**

#### 6.1 Дотоодын сургалттай холбоотой гарсан зөрчлийн талаар:

1. Төсвийн гүйцэтгэлээс харахад хичээл үйлдвэрлэлийн дадлага буюу төгсөлтийн дараах сургалтанд төрийн сангийн тэтгэлэгээр суралцагсадын сургалтын төлбөр, тэтгэлэгийн зардал 2016 онд 111.602,6 мянган төгрөг, 2017 онд 109.675,6 төгрөг хэмнэгдсэнд:

- Эрүүл мэндийн сайдын сургалтын зардал, хяналтын тоо батлах тухай тушаалаар батлагдсан тооноос төрөлжсөн мэргэжилтэн, тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн орон нутгаас ирж суралцаагүй нь нөлөөлсөн байна. Мөн 2016 онд сургалт эхлэх хугацаа хойшлогдож, 11 дүгээр сард эхэлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн захиалгын дагуу ирж суралцах эмнэлгийн мэргэжилтэнүүд ирж суралцахгүй байгаа шалтгаан нь тухайн мэргэжлийн чиглэлээр орлон ажиллах мэргэжилтэн байхгүй, хөдөө орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин дутмаг байгаатай холбоотой бөгөөд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дах "Сум, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмчийн салбарт 5 ба түүнээс дээш жил

ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 жил тутамд улсын зардлаар хамруулна.” гэсэн заалтын дагуу ЭМГ-ын дарга нар дээрх байдалд дүгнэлт хийж захиалгыг бодитой хийж ирүүлж хуулийн хэрэгжүүлэн ажиллах хэрэгтэй байна.

Дээрх байдал жил бүр давтагддаг тул ЭМХТ-өөс элсэлт болон эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалттай холбоотойгоор орон нутгийн ЭМГ-ын дарга нартай уулзалт зохион байгуулан мэдээлэлээр хангаж цаашид зохион байгуулалтанд анхаарч ажиллах зүйлсийг харилцан ярилцах, ЭМЯ-тай хамтран зохион байгуулсан “хүний нөөцийн менежерийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж төгсөлтийн дараах сургалтын төлөвлөлт, захиалга хийх арга зүй, хичээлийн жилийн үндсэн болон төрөлжсөн мэргэшүүлэх сургалтын дүнг танилцуулах зэрэг арга хэмжээ авсан ч үр дүнд хүрээгүй байна.

Цаашид эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах хүний тоог бодит бус гаргаж захиалга өгч, захиалгын тоог хийсвэрээр өсгөж байгаа нь

- Төсвийн төлөвлөлт,

- Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байгаа бөгөөд дээрх хэмнэгдсэн төсвийг зориулалт бусаар зарцуулж болохгүй тул оны эцсээр 2016 онд 180.775,8 төгрөг, 2017 онд 165.566,7 төгрөг хэмнэж Сангийн яаманд татан төвлөрүүлсэн байна.

Иймд дээрх мөнгө нь эрүүл мэндийн ажилтаны боловсрол дээшлүүлж, ажиллах нөхцөл бололцоог хангахад зарцуулагдахгүй байгаа тул **Эрүүл мэндийн тухай хуулийн 46 зүйлийн 46.1 дэх “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн заалтын дагуу ЭМГ-уудын дарга удирдлагад хариуцлага тооцож ажиллах нь зүйтэй байна.**

- Суралцагсадын сургалтын төлбөр, тэтгэлэгийн захиалгыг үндэслэн Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугаар тушаалыг үндэслэн 1 суралцагчийн сарын сургалтын төлбөрийг 16,0 мянган төгрөг, тэтгэлэгийг 300,0 мянган төгрөгөөр төсөвлөн, мөнгийг олгохдоо суралцагсадын ирцийг үндэслэн гүйцэтгэлээр олгодог нь нөлөөлсөн байна.

- Төгсөлтийн дараах сургалтад элсэгчдийг элсэлтийн шалгалтад бэлдүүлэх, дэмжлэг үзүүлэх ажлыг захиалагч байгууллага хангалтгүй хийж ирсэн байна.

2. Үндсэн мэргэжлийн 2 жилийн сургалтанд хувийн зардлаар сурч байсан М.Сэрсмаад 2.430,0 мянган төгрөг ЭМХТ-ийн ерөнхий захирал Ч.Бат-эрдэнэ 2016 оны 09 дүгээр сарын 21-нд А/121 дугаар тушаал, Ж.Алтанхуягт 2.970,0 мянган төгрөг ЭМХТ-ийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Нарантуяа 2017 оны 4 дүгээр сарын 20-нд А/64 дугаар тушаалыг нөхөн гаргаж 2016 оны 12 дугаар сарын 22-нд сургалтын тэтгэлэг 5.400,0 мянган төгрөг төрийн сангийн санхүүжилтээр суралцагчаар нөхөн олгосон нь байна. Энэ нь Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Хяналтын тоо, зардал батлах тухай” 141 тушаалыг зөрчсөн байна.

3. ЭМСС-ын 2016 оны 04 дүгээр сарын 2/1601 дугаар албан бичгийг үндэслэн орон нутагт “Сум тосгоны ЭМТ-ийн санхүүжилтийн аргачлал” сургалт зохион байгуулахаар 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ЭМСЯ-ны СЭЗХэлтсийн мэргэжилтэн н.Мөнхцэцэг сургалтын зардалд 25021.9 мянган төгрөгийг бэлнээр авсан байна.

Сургалтыг явуулсан иргэн ЭМЯ-ны СЭЗХ-ийн төсвийн төлөвлөлтийн зөвлөх А.Батбаяр /ЭМЯ-ны СЭЗХ-т албан ёсны зөвлөх ажилладаггүй/-тай гэрээ байгуулаагүй



бөгөөд иргэн А.Батбаяр иргэн н.Цолмонтой программ зохиох 5.000,0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, мөнгө олгосон, тайланд томилолтын зардалд нэг хүнд 30.0 мянган төгрөг хавтгайруулан олгосон нь үндэслэлгүй байна. Иймд дахин дээрх маягийн сургалтыг орон нутагт явуулахдаа томилолтын хуудас авч түүнийг очсон ЭМГ-ын дарга нараар бөглүүлэх, мөн холбогдох анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах шаардлагатай байна.

## **6.2 Гадаад сургалттай холбоотой гарсан зөрчлийн талаар:**

1. 2017 онд 515,9 сая төгрөг төсөвлөснөөс 593,2 сая төгрөг зарцуулж 77,2 сая төгрөгөөр тухай зардлыг хэтрүүлэн зарцуулсан бөгөөд **2017 оны Эрүүл мэндийн сайдын сургалтын зардал, хяналтын тоо батлах тухай тушаалд гадаад сургалтын хяналтын тоог заагаагүйч нийт 126 эмнэлгийн мэргэжилтэн сургалтанд хамрагдсанд:**

➤ ЭМХТ-ийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нарантуяа ЭМС-ын 2016 оны А/203 дугаар тушаалыг үндэслэн 2017 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн А/81 дугаар тушаалаар Арабын нэгдсэн Эмират Улсын Дубай хотод зохион байгуулагдах “Төсвийн төлөвлөлт, санхүүгийн аргачлал” сэдэвт сургалтанд 8 хүнийг хамруулан 39.044,5 мянган төгрөг,

➤ 2017 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн А/159 дугаар тушаалаар Хонг Конг Улсад 2017 оны 09 дүгээр сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулагдах “Төсвийн төлөвлөлт, санхүүжилт, тайлагналт, санхүүгийн хяналт, аргачлал” сэдэвт сургалтанд 4 хоногт 7 хүн хамруулан 27.641,6 мянган төгрөг нийт 66.686,1 мянган төгрөг зарцуулсан нь байна. **Энэ дээрх зардлын 11.2 хувийг эзлэж байна.**

Нэр бүхий хүмүүсийг ямарч сонгон шалгаруулалтгүй, гадны байгууллагын хүмүүсийг авч явсан, сургалтанд хамрагдаагүй, ЭМХТ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяагийн гаргасан тушаал нь ЭМС-ийн “Сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай” 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/188 дугаар тушаал, Эрүүл мэндийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 119 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах” журмыг зөрчсөн байна.

Мөн дээрх сургалтанд зарцуулсан мөнгөний анхан шатны баримт огт байхгүй байна.

2. 2016-2017 онуудад эмнэлгийн ажилтануудыг гадаад сургалтанд явуулахдаа **Эрүүл мэндийн 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 119 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтанд хамруулах” журмыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тухайлбал:**

- 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдөр ЭМСЯ-ны СЭЗХэлтсээс Эрүүл мэндийн салбарын эдийн засагч, нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулан 22.876,8 мянган төгрөг зарцуулсныг шалгахад 23000.0 мянган төгрөгийн төсвийг Сэлэнгэ аймагт сургалтыг зохион байгуулахаар ЭМЯ-ны СЭЗХ-ийн даргаар батлуулсан, сургалтын тайлан нь Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн байгууллагын тайлангийн слайдыг хэвлэж хийсэн, анхан шатны баримт хангалтгүй бөгөөд дээрх зардлаар ОХУ-ын Улаан-Үдэ явсан байна.

3. ЭМС-ийн 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/103 дугаар тушаалаар Монгол Улсын Эрүүл мэндийн Яам, Бүгд Найрамдах Сингапур Улсын Нанянг Политехникийн их сургууль хоорондын Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн сургах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 03-наас 14-ний өдрүүдэд менежерийн түвшний эхний ээлжийн сургалтанд хамрагдах хүмүүсийн тушаалыг гаргасан байхад ЭМХТ-ийн ерөнхий

захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нарантуяа ЭМС-ын тушаалыг зөрчин 2017 оны 03 дугаар сарын 29-нд А/51 дугаар тушаал гарган ЭМХТ-ийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Тамирыг дээрх сургалтанд хамруулах тушаал гарган 2.747,9 мянган төгрөг зарцуулсан байна. Мөн дээрх сургалтанд зарцуулсан мөнгөний анхан шатны баримт огт байхгүй байна.

1. 2016 оны 09 дүгээр сарын 02-нд ЭМХТ-ийн захиралын 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/124 дугаар тушаалаар захиргаа аж ахуйн албаны дарга Л.Оюунчимэг 10 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд Энэтхэг Улсад зохион байгуулагдах олон улсын дээд хэмжээний уулзалтанд Энэтхэгийн засгийн газрын санхүүжилтээр оролцохоор явахдаа 2016 оны 10 дугаар сарын 5-нд кассаас бэлнээр 9000 ам доллар /1ам доллар 2287/ буюу 20.583,0 төгрөг авч яван Энэтхэгийн Global Care эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу сургалтын урьдчилгаанд 2016 оны 10 дугаар сарын 05-нд тушаасан байна.

Энэтхэгийн Global Care эрүүл мэндийн байгууллагад сургалтанд хамрагдсан байдлыг шалгахад тус байгууллагад хүмүүс суралцаагүй харин Фортис ескорт зүрхний төвд сонгон шалгаруулалтанд тэнцсэн 4 их эмчийг 2017 оны 1 дүгээр сарын 09-нөөс 02 дугаар сарын 03-ныг хүртэл 1 сарын хугацаанд ЭМХТ-ийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар суралцуулан, тийзний үнэнд 2017 оны 01 дүгээр сарын 06-нд 7.730,8 мянган төгрөгийг 2016 оны 12 дугаар сарын 27-нд 3.000,0 мянган төгрөг олгосон байна. /Хэн хэзээ явсан тодорхойгүй байна. Анхан шатны баримтгүй байгаа үлдэгдлийг баталгаажуулж дахин шалгуулах/

### **6.3 Санхүүтэй холбоотой зөрчлийн талаар:**

1. Сургалтын тэтгэлэгийг суралцагч байгууллагуудын ирцийг үндэслэн журмын дагуу сард ойролцоогоор 80-105 сая төгрөгийг олгож ирсэн байна. Гэвч дээрх мөнгийг няравын ЖМС-ын дансруу шилжүүлэн түүнийг нярав суралцагч нарын картруу шилжүүлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлээнэ.", гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Цаашид суралцагсадын суралцах хугацаанд тэтгэлэг болон сургалтын төлбөр өгөгдөж байгаад нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

### **6.4 Бусад зөрчлийн талаар:**

1. Сувилахуйн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд сувилахуйн мэргэжлийн туслах сувилагч бэлтгэх хэрэгцээ нэн шаардлагатай байгаад эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс хөтөлбөр баталсны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиралын 2016 оны 09 дүгээр сарын 22-ны А/122 дугаар тушаалаар туслах сувилагч бэлтгэх 3 сарын 20 багц цагийн сургалтыг АШУИС-д бэлтгэн зардалд 32.000,0 мянган төгрөгийг "Удирдах ажилтны сургалт", "Хүний нөөцийн менежерүүдийн сургалт"-ын зардлаас шилжүүлэн зарцуулсан нь Эрүүл мэндийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/184 дугаар "Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай" тушаал, ЭМСС-ын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай" А/111 дугаар тушаалыг зөрчсөн байна. /Мэргэжлийн индексгүй мэргэжилд сургалт явуулсан, төгсөгчид сувилагчийн ангилалаар цалинжих шаардлагатай болсон/

2. Кассын тайланг шалгахад 2017 оны 02 дугаар сарын 09-нд 2017 оны суралцагсадын тэтгэлэгт 93.366,9 мянган төгрөг бэлнээр олгосныг шалгахад дээрх мөнгийг:

- Суралцагсадын тэтгэлэгт 45.928,4 мянган төгрөгийг олгосон.

- Шинээр томилогдсон ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа хамтарч ажиллахгүй албаны дарга нар болон санхүү, аж ахуйн ажилтануудыг ажлаас чөлөөлөхийн тулд 3 сарын үндсэн цалингийн хэмжээтэй тэнцэх нийт 39.403,2 мянган төгрөгийг “Сургалтын зардал батлах тухай” 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/03 дугаар тушаал гарган нэр бүхий 10 хүнийг мэргэшүүлэх сургалтанд хамруулахад сургалтын зардлын дэмжлэг үзүүлэх нэрээр зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Дээрх тэтгэлэгийн мөнгийг 2017 оны 06 дугаар сарын 16-нд касст сургалт, семинарийн зардлаас нөхөн байршуулсан байна.

***Иймд дээрх зөрчил улсын ахлах байцаагчийн акт тогтоон төлбөрийг буруу шийдвэр гаргасан хүнээр төлүүлэх нь зүйтэй байна.***

3. ЭМХТ-ийн захирал Ч.Бат-Эрдэнэ “Ньюглобал тех” ХХК-тай программ хангамж боловсруулах ажлын гэрээг 2016 оны 08 дугаар сарын 02-нд “Н-info 3” программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах, шинэчлэлт, өөрчлөлт хийх, статистик тайлан мэдээ боловсронгуй болгох зорилгоор сар бүр 2500,0 мянган төгрөгөөр төлж 2 жилийн хугацаагаар байгуулж ажлыг хийж дуусгах, 2 жилийн дараа программын эх код өгөгдлийн санг захиалагч талд 50.000,0 мянган төгрөгөөр үнэлж өгөхөөр байгуулан түүний төлбөрт 2016 онд 10.000,0 мянган төгрөгийг төлсөн байна.

Гэтэл 2017 онд ЭМХТ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нарантуяа 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр дээрх программ, түүний эх кодыг “Кредо Терра” ХХК-тай 27.500,0 мянган төгрөгөөр худалдах худалдан авах гэрээг байгуулан төлбөрийг барагдуулан эх кодыг хүлээж авч ажилласан байна. Иймд дээрх үйлдэл нь хуулийн дагуу явагдсан эсэхийг дахин шалгах нь зүйтэй байна.

4.2017 оны ЭМХТ-ийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нарантуяа, ДЭМБ-гаас Үндэсний эрүүл мэндийн мэдээлэлийн тогтолцоог боловсронгуй болгоход байгууллагын чадавхийн бэхжүүлэх нь 2017 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2016 онд сайжруулсан системийг шинэчлэх, бусад системийг боловсронгуй болгох, Эрүүл мэндийн мэдээллийг олон нийтэд хүргэх тухай хууль болон алсын зайн эмчилгээний тухай хуулийн төслийг боловсронгуй болгох 40.536,7 мянган төгрөгийн гэрээ байгуулан ажилласныг шалгахад программист мэргэжлийн хүмүүсийг хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллуулан тэдгээр хүмүүсийн цалинд олгосон байна. Дээрх төсөл нь 2016 оноос хэрэгжиж ирсэн гэх боловч ДЭМБ-тай байгуулсан гэрээ олдохгүй байсан болон төслийн зохицуулагч өвчтэй байсан зэргээс дээр материалтай танилцаж шалгаж чадаагүй тул 2018 оны 11 дүгээр сарын төлөвлөгөөт шалгалтаар дахин шалгалт хийх.

**2. Гурвалсан гэрээгээр нийт 613 төгсөгч буюу 90.5 хувь нь захиалгат эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бол 64 төгсөгч буюу 9,5 хувь нь ажиллаагүй байна.**

Иймд Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 5.1-д “Ажлын алба нь төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж буй байгууллагад олгосон сургалтын зардлын зарцуулалтанд тогтмол хяналт тавьж ажиллах бөгөөд ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон захиалгат хяналт-шинэжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийнэ.” гэж

